Үндэсний аудитын газар | Аудитын гуравдугаар газрын захирал Д.Энхболд

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮР ДҮН, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАЙДАЛД 2019 ОНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН




# АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ

Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу УИХ-ын Төсвийн байнгын хорооноос Үндэсний аудитын газрын тухайн онд хийх аудитын сэдвийг баталдаг билээ.

Монгол Улсын Хөгжлийн Банкны уг аудитыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хорооны 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 11/9920 дугаар албан бичиг, Төсвийн байнгын хорооны 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 9/10647 дугаар бичиг бичиг, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хийсэн болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аудитыг Монгол Улсын Хөгжлийн банкны 2012-2017 оны үйл ажиллагааг хамруулсан бөгөөд ҮАГ-аас тусгайлан эрсдэлийн болон нийцлийн аудит хийсэн болон хууль хяналтын байгууллагад шалгагдаж байсан дараах төсөл, хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг уг аудитад хамруулаагүй болно Үүнд:

- ✓ *“Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалт “АСЕМ”-ыг зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний гүйцэтгэл, үр дүн”;*
- ✓ *“Гудамж” төслийн нийслэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”*
- ✓ *“Монлаа” ХХК төмрийн хүдрийг нойтон аргаар баяжуулах үйлдвэр байгуулахаар 5.6 тэрбум төгрөгийн зээл,*
- ✓ *“Эгийн голын усан цахилгаан станц” төслийн баримт материал,*
- ✓ *МУХБ-наас олон нийтэд мэдээлэл түгээхтэй холбоотой зарим ажил.*



UIH.MN




# АУДИТЫН ЗОРИЛТУУД

Монгол Улсын Хөгжлийн Банкны зорилго, зорилт, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй зохион байгуулагдсан эсэх;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



**ЗОРИЛТ 2**

# АУДИТЫН ЗОРИЛТУУД

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үр ашигтай, эрсдэлгүй удирдаж байгаа эсэх;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЗОРИЛТ 3

# АУДИТЫН ЗОРИЛТУУД

Зээл олголтын үйл ажиллагаа үр дүнтэй, хууль, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЗОРИЛТ 4

# АУДИТЫН ЗОРИЛТУУД

Банкны үйл ажиллагаанд хяналтын үр нөлөөтэй тогтолцоо үйлчилж байгаа эсэх;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 1-ИЙН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД

**А**

Эрх зүйн зохицуулалт хангалтгүй, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрэн бүрдээгүй байжээ.

**Б**

Банкны захиргааны нэгжийн орон тоо банкны үйл ажиллагаатай бүрэн уялдаагүй байна.

**ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ХАНГАЛТГҮЙ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО БҮРЭН БҮРДЭЭГҮЙ БАЙСАН ТӨДИЙГҮЙ БАНКНЫ БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ БҮРЭН УЯЛДААГҮЙ БАЙНА.**

**В**

Арвилан хэмнэлттэй ажиллах зарчмыг хангаагүй, үр ашиггүй зарцуулалт хийж иржээ.

**Г**

Худалдан авах ажиллагаанд мөрдөж буй журмын зохицуулалт хангалтгүй байгаа нь арвилан хэмнэлтгүй худалдан авалт хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байх тул ТБОНӨХБАҮХАТХ-ийг мөрдөх нь зүйтэй байна.

UILMIN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 1-ИЙН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:



Монгол Улсын Хөгжлийн Банкны зээл олгох үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулах;



ТБОНӨХБАУХАТХ-ийг мөрдөх талаар хууль, эрх зүйн орчныг сайжруулах;



Банкны үйл ажиллагааны төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах;



10.2 тэрбум орчим төгрөгийн хохирол учруулсан байж болзошгүй асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 2-ЫН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД

**ТООЦОО СУДАЛГААГҮЙГЭЭР ЭХ ҮҮСВЭР ТАТАЖ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГЫГ ЗОХИСГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ИХ ХЭМЖЭЭНИЙ АЛДАГДАЛ ХҮЛЭЭСЭН БАЙНА.**

**А**

Бэлтгэл ажлыг бүрэн хангахгүйгээр бонд гаргасан, зарим бондын эх үүсвэр татах үйл ажиллагааны зардал өндөр байгаа нь бодит хүү нэмэгдэхэд хүргэсэн байна.

**Б**

2012-2015 онд мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс их хэмжээний орлого олох боломжийг алдаж, 102.1 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээсэн байна.

**В**

Самурай бондын 30.0 тэрбум иенийг ханшийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авалгүйгээр бусад валютад шилжүүлснээс 2014-2017 онд 102.1 тэрбум төгрөгийн ханшийн тэгшитгэлийн алдагдал хүлээсэн.

**Г**

Арилжааны банкнуудад зарим хадгаламжийг Монгол банкны бодлогын хүү, эх үүсвэрийн хүүгийн түвшнээс бага хүүтэйгээр байршуулснаас нийт 17.4 тэрбум төгрөг, 0.9 сая ам.долларын орлого олох боломжийг алдсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 2-ЫН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:




Активын оновчтой удирдлага хэрэгжүүлэх замаар гадаад валютын ханшийн алдагдлыг бууруулах, эрсдэлийг хянан удирдаж ажиллах;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 3-ЫН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД

**01** Төслийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт иж бүрэн бус, зээл олголтод мөрдөгдөж буй дүрэм, журмын зохицуулалт хангалтгүй байсан.

**02** Зарим зээл зорилго, зорилтод нийцээгүй, УИХ-аас батлаагүй хөтөлбөрүүдэд арилжааны банкнуудаар дамжуулан зээл олгосон.

**03** Арилжааны банкаар дамжуулан зээлийн багц, төслийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн багцын хувьд хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй.

**04** МУХБ-ны санхүүжүүлсэн зарим төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хангалтгүй, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй.

**05** Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмуудын зохицуулалт хангалтгүй, арилжааны банкаар дамжуулан олгосон зарим зээл зориулалтын дагуу ашиглагдаагүй.

**06** Нийт зээлд эзлэх чанаргүй болон анхаарал хандуулах зээл 2017 оны жилийн эцсийн байдлаар 28.2 хувь

**07** Зарим зээлийн ашиглалт муу, эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрч байгаа нь төслийн үнэлгээ хангалтгүй хийгдсэнтэй холбоотой байсан.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 3-ИЙН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:

Зээлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй журмуудыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх;

МУХБ-наас олгох төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, үр дүнд үндэсний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг бодитой, үнэлж, дүгнэх хяналтын тогтолцооны үйлчлэлийг сайжруулах;

Ашиглалт муу, эргэн төлөлт хангалтгүй, ангилал буурсан төслүүдийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 4-ИЙН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮД

**Банкны үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо 2017 оноос бүрджээ.**

Дотоод хяналтын тогтолцоо 2017 оныг хүртэл бүрэн бүрдээгүй байжээ.

Монгол банкнаас тогтоосон хязгаарлалт, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд тухайн үед хангагдаж байжээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЗОРИЛТ 4-ЫН ХҮРЭЭНД АУДИТААР ИЛЭРСЭН ГОЛ ЗӨРЧЛҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ:



Банкны үйл ажиллагаанд тавигдах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг оновчтой, иж бүрэн, зохистой түвшинд тогтоон мөрдүүлж, хяналт тавьж ажиллах;

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗЭЭЛ ОЛГОЛТЫН ҮР ДҮН, ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН БАЙДАЛД 2019 ОНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

# АЛБАН ШААРДЛАГА



4

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 05 дугаар сарын 17 № 01/288 Улаанбаатар хот
ГАГ-2017-12-ГА

Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай

Үндэсний аудитын газраас УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06, 2019 оны 04 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас 2019 онд нэгдсэн удирдамжаар болон Үндэсний аудитын газрын гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн "Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа, зээл олголтын үр дүн, эргэн төлөлтийн байдал"-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах нөхцөл байдал илэрлээ. Үүнд:

- Хавсралтад дурдсан 28 зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрч, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү зэрэгт нийт 569,752,213,429.93 төгрөг төлөгдөөгүй байна.
  Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банк нь уг асуудлыг шийдвэрлүүлж, зээлдэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулаагүй байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.3, 21.6.7-д заасан банкны гүйцэтгэх удирдлагын үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

- Засгийн газрын холбогдох тогтоолуудыг үндэслэн Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс хөгжлийн төсөл гэж үзэн 2016 оны жилийн эцэст Сангийн яаманд шилжүүлээгүй Эгийн голын усан цахилгаан станц, Тавантолгойн цахилгаан станцын төслүүдэд олгосон зээлийн хөрөнгийг зөвлөх үйлчилгээ, ТЭЗҮ боловсруулах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, төслийн нэгжийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зэрэгт зарцуулагдсан боловч уг төслүүд зогсонги байдалд орж, зээл эрсдэж болзошгүй нөхцөл үүссэн,
- Монгол Улсын Хөгжлийн банкнаас олгосон зээлээр худалдан авсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 239 км хатуу хучилттай авто замын чиглэлд авто зам болон төмөр замын шинэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаатай холбоотойгоор тус авто зам цаашид эдийн засгийн үр ашиггүй болж зээл эрсдэж болзошгүй нөхцөл байдал үүссэн байна. /Хавсралт 2/
  Монгол Улсын Хөгжлийн банкны зүгээс уг эрсдэлийг бууруулах арга хэмжээ аваагүй байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6.9 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

| № | Зээлдэгч | Валют | Хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн төлбөр | Хугацаа хэтэрсэн хүүний төлбөр | Торгуулийн хүү | Нийт хугацаа хэтэрсэн өр | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | валютаар | төгрөгөөр |
| 1 | Мон лаа ХХК | MNT | 5,642,970,000.00 | 2,270,695,296.63 | 71,477,620.00 | 7,985,142,916.63 | 7,985,142,916.63 |
| 2 | Хөтөл ХХК | USD | 12,500,000.00 | 24,238,466.58 | 138,050.96 | 36,876,517.54 | 97,461,685,736.82 |
| 3 | Капитал банк | MNT | 36,851,871,876.00 | 1,377,773,654.90 | 229,588,461.01 | 38,459,233,991.91 | 38,459,233,991.91 |
| 4 | ТОСК ТӨҮГ | USD | - | 4,561,456.11 | 75,883.19 | 4,637,339.30 | 12,256,116,782.76 |
| 5 | Ти Жи Вай ХХК | MNT | 343,588,971.97 | 1,129,607.58 | 225,921.52 | 344,944,501.07 | 344,944,501.07 |
| 6 | Болор шүр ХХК | JPY | 104,824,320.27 | 9,304,953.36 | 1,765,052.23 | 115,894,325.86 | 2,774,510,161.09 |
| 7 | Эрд хул ХХК | MNT | 530,747,447.52 | 46,119,325.09 | 5,472,209.22 | 582,338,981.83 | 582,338,981.83 |
| 8 | Сонгоулд ХХК | JPY | 48,973,880.62 | 50,775,066.50 | 227,139.11 | 99,976,086.23 | 2,393,427,504.35 |
| 9 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | MNT | 1,159,167,659.16 | - | 1,892,878.06 | 1,161,060,537.22 | 1,161,060,537.22 |
| 10 | Инжир ХХК | USD | - | 130,380.99 | - | 130,380.99 | 344,586,526.09 |
| 11 | Хамтын эх булаг ХХК | JPY | 32,537,969.69 | 1,148,053.29 | 127,477.51 | 33,813,500.49 | 809,495,201.73 |
| 12 | Ган хүдэр орд ХХК | JPY | - | 12,369,404.17 | - | 12,369,404.17 | 296,123,535.83 |
| 13 | Монгема ХХК | JPY | 11,648,529.44 | 6,795,720.16 | 8,919.88 | 18,453,169.48 | 441,768,877.35 |
| 14 | Хатант интернэшнл ХХК | MNT | 5,149,805,478.67 | 50,792,601.98 | 10,786,248.15 | 5,211,384,328.80 | 5,211,384,328.80 |
| 15 | Пи си вай ХХК | MNT | 1,101,373,881.29 | 37,891,766.01 | 1,316,875.23 | 1,140,582,522.53 | 1,140,582,522.53 |
| 16 | Пирамид-орд ХХК | MNT | - | 1,243,986,849.31 | - | 1,243,986,849.31 | 1,243,986,849.31 |
| 17 | Мбү трейд ХХК | MNT | - | 718,266,489.67 | - | 718,266,489.67 | 718,266,489.67 |
| 18 | Петролеум продакшн ХХК | MNT | 239,448,333.33 | 126,940,417.81 | 59,042.05 | 366,447,793.19 | 366,447,793.19 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# АЛБАН ШААРДЛАГА



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн нэр бүхий зээлдэгчдийн өр төлбөрийг барагдуулах, төлүүлэх талаар холбогдох хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,
2. Зээлийн эргэн төлөлт эрсдэлд орсон 3 зээлд анхаарч, зээлийг хугацаанд нь төлүүлэх, эрсдэлийг бууруулах талаар холбогдох хууль, тогтоомжийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Хөгжлийн банкны Гүйцэтгэх захирал Б.Батбаярт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХ-ОЧИР
АХЛАХ АУДИТОР Б.ХИШИГТОГТОХ
АУДИТОР И.ТУЯАДАРЬ

ЗӨВШӨӨРСӨН:
МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БАТБАЯР

ХУУЛБАР ҮНЭН

| № | Зээлдэгч | Валют | Хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн төлбөр | Хугацаа хэтэрсэн хүүний төлбөр | Торгуулийн хүү | Нийт хугацаа хэтэрсэн өр | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | валютаар | төгрөгөөр |
| 19 | Мак цемент ХХК | USD | 55,599,983.98 | 9,978,525.48 | 508,566.37 | 66,087,075.83 | 174,662,854,452.62 |
| | | MNT | 20,000,000,000.00 | 5,784,740,891.68 | 208,577,777.78 | 25,993,318,669.46 | 25,993,318,669.46 |
| | | | | | | | 200,656,173,122.08 |
| 20 | Кьюэс си ХХК | USD | 61,299,999.99 | 3,746,111.12 | 241,231.10 | 65,287,342.21 | 172,549,222,473.65 |
| 21 | Форс голд майнинг ХХК | MNT | 1,965,155,647.78 | 133,672,303.00 | 16,750,637.70 | 2,115,578,588.48 | 2,115,578,588.48 |
| 22 | Скайлэнд энержи ХХК | MNT | 284,952,417.33 | 12,619,694.54 | 1,362,282.61 | 298,934,394.48 | 298,934,394.48 |
| 23 | Нью хаппи ХХК | MNT | 1,473,845,106.15 | 96,020,090.46 | 7,183,596.07 | 1,577,048,792.68 | 1,577,048,792.68 |
| 24 | Монгол драй милк ХХК | USD | - | 1,854,809.55 | - | 1,854,809.55 | 4,902,113,255.89 |
| 25 | Кредос ХХК | JPY | 91,468,758.76 | 25,681,420.26 | 173,665.31 | 117,323,844.33 | 2,808,732,833.26 |
| 26 | Бэрэн групп ХХК | USD | 1,801,387.56 | 983,643.92 | 5,206.81 | 2,790,238.29 | 7,374,376,581.41 |
| 27 | Монватт ХХК | EUR | 206,559.78 | 552.93 | 190.1 | 207,302.81 | 627,847,655.51 |
| 28 | Вояжер минерал ресурсес ХХК | JPY | 119,087,942.01 | - | 4,894.01 | 119,092,836.02 | 2,851,082,494.32 |
| | | MNT | 74,742,926,819.20 | 11,900,648,988.66 | 554,693,549.40 | 87,198,269,357.26 | 87,198,269,357.26 |
| | | USD | 131,201,371.53 | 45,493,393.75 | 968,938.43 | 177,663,703.71 | 469,550,955,809.23 |
| | Нийт дүн | EUR | 206,559.78 | 552.93 | 190.1 | 207,302.81 | 627,847,655.51 |
| | | JPY | 408,541,400.79 | 106,074,617.74 | 2,307,148.05 | 516,923,166.58 | 12,375,140,607.93 |
| | | Төгрөг | 431,903,734,075.88 | 134,677,150,178.55 | 3,171,329,175.50 | 569,752,213,429.93 | 569,752,213,429.93 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ХУУЛЬ ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГАД ШИЛЖҮҮЛСЭН АСУУДЛУУД

Үндэсний аудитын газраас 7 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлснээс 2 асуудалд гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон боловч хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн, 1 асуудалд хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж, 3 асуудалд хэрэг нээж шалгаж байгаа тухай хариу ирүүлсэн байна.

| № | Хууль, хяналтад шилжүүлсэн агуулга | Шийдвэрлэсэн байдал<br>/УЕПГ-ын 2022.02.22-ны өдрийн 5/1186 дугаар албан бичиг, 2022.03.04-ний өдрийн 4/1457 дугаар албан бичиг/ |
|---|---|---|
| 1 | Нийт 3,240.0м2 талбай бүхий ажлын байрны зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хэт өндөр үнээр худалдан авсан шийдвэр нь 10.2 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байж болзошгүй асуудал,<br><br>Мөнгөн хадгаламж, Засгийн газрын үнэт цаасны хүүгийн зөрүү болон мөнгөн хадгаламжийг хугацаанаас нь өмнө буцаан дуудсан зэргээс шалтгаалан хүүгийн зөрүүтэй байгууллагад болон улсад хохирол учруулсан, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй асуудал, | Шүүхээс шүүгдэгч Б.Шинэбаатар, Ч.Отгочулуу нарыг цагаатган, шүүгдэгч Н.Мөнхбатыг 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.2-т зааснаар "хөөн хэлэлцэх хугацаа дууссан" үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн |
| 2 | Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яамны захиалгаар Увс аймагт баригдсан 2500 суудалтай наадмын талбайн төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажил бодитой эсэх, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байх эрсдэлтэй асуудал, | Нийслэлийн прокурорын газраас уг асуудлыг эрүүгийн журмаар шалгуулан 2019.09.16-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор хэрэг бүртгэлийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн байна. |
| 3 | МУХБ-ны ТУЗ-ийн 2017.09.07-ны өдрийн 75 дугаар тогтоолоор “Ачлал трейд” ХХК-д эмнэлгийн барилга угсралт, дахин санхүүжилтэд зориулж 15.0 сая хүртэл ам.долларын зээлийг олгохоор шийдвэрлэсэн нь хууль тогтоомж зөрчсөн эсэх, бусдад давуу байдал олгосон эсэх асуудал, | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгаж байна. |
| 4 | “Шинэ яармаг” хорооллын 20 ширхэг орон сууцны үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээг хүчин төгөлдөр бус гэж шийдвэр гарснаар зээл барьцаагүй болсон. | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанаар эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байна. |
| 5 | Бейзмент /Хөтөл ХХК зээлийг эргэн төлөхөөс зайлсхийсэн, үйлдвэрийн өргөтгөлийн барилгыг барьцаалуулах үүргээ биелүүлээгүй, улсын комисс хүлээж аваагүй үйлдвэр үйл ажиллагаа явуулж байгаа нь хууль тогтоомжид нийцэх эсэх асуудал, | Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 22.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасанаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. |
| 6 | Зээлийг зориулалт бусаар зарцуулсан нэр бүхий компаниудад зээл олгосон асуудал хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх, ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг шалгуулах<br>- “Файнаншл алиянс” ХХК, малын тэжээлийн үйлдвэр барих төслийн 18.0 тэрбум төгрөгийн зээл,<br>- “Драгон холдинг” ХХК ,“Цэвэр ус савлах, сав баглаа боодлын үйлдвэр байгуулах төсөл" 8.4 тэрбум төгрөгийн зээл,<br>- “Гранд стони” ХХК, элс хайрганы карьер 1.4 тэрбум төгрөгийн зээл,<br>- “Чойр хайрхан” ХХК, ноос ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төслийн 1.3 тэрбум төгрөгийн зээл. | Төр нийтийн ашиг сонирхолд хохирол учирсан эсэхэд дүгнэлт хийх шаардлагатай байна гэж үзэн 2019.08.27-ны өдөр 5/4350 дугаартай мэдээлэл хүсэх тухай албан бичиг хүргүүлсэн.<br>Хөгжлийн банкны 2019.10.15-ны өдрийн 3/1283 дугаар албан бичигт:<br>- “Файнаншл алиянс” ХХК зээлийг бүрэн төлж барагдуулсан,<br>- “Драгон холдинг” ХХК зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй тул эргэж татахыг мэдэгдсэн мэдэгдэл хүргүүлсэн, гэхдээ тус компани зээлээ хэвийн төлж байгаа,<br>- “Гранд стони” ХХК, зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй тул эргэж татахыг мэдэгдсэн мэдэгдэл хүргүүлсэн, гэхдээ тус компани зээлээ бүрэн төлж дуусгасан,<br>- “Чойр хайрхан” ХХК хөтөлбөр дуусгавар болсон тул зээл хаагдсан гэсэн хариуг прокурорын байгууллагад хүргүүлжээ. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

ҮАГ-аас 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/288 ГАГ-2017-10-ГА дугаартай албан шаардлагаар эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 28 зээлдэгчийн 569.8 тэрбум төгрөгийн эргэн төлөлтийг төлүүлэх, эргэн төлөлтийн эрсдэлд орсон 237.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй 3 зээлд анхаарч, зээлийг хугацаанд нь төлүүлэх, эрсдэлийг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллахыг даалгасан.

2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар дээрх 28 зээлээс 6 зээл хаагдсан ч үлдсэн 22 зээлийн төлөлт хангалтгүй нийт зөрчлийн дүн 919.4 тэрбум төгрөг болсон байна. Эргэн төлөлтийн эрсдэлд орсон 3 зээлийн үлдэгдэл 242.5 тэрбум төгрөг болж, бодитой үр дүн гараагүй байна. Албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ ХУГАЦАА ХЭТЭРСЭН ЗЭЭЛҮҮД

| № | Зээлдэгч | Валют | 2019 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн албан шаардлагын дүн | | | 2022 оны байдлаарх төлөгдөөгүй зээлийн зөрчлийн дүн | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үндсэн зээлийн өр | Үндсэн болон торгуулийн хүүгийн өр | Нийт зөрчлийн дүн | Үндсэн зээлийн өр | Үндсэн болон торгуулийн хүүгийн өр | Нийт зөрчлийн дүн | |
| 1 | Мон лаа ХХК | MNT | 5.6 | 2.3 | 8.0 | 5.2 | 2.4 | 7.6 | |
| 2 | Хөтөл ХХК | USD | 0.0 | 0.0 | 97.5 | 175.3 | 122.2 | 297.5 | |
| 3 | Капитал банк | MNT | 36.9 | 1.6 | 38.5 | 52.0 | 2.5 | 54.4 | |
| 4 | ТОСК ТӨҮГ | USD | - | 0.0 | 12.3 | 29.3 | 55.7 | 84.9 | |
| 5 | Ти Жи Вай ХХК | MNT | 0.3 | 0.0 | 0.3 | | | | Зээлийг хаасан |
| 6 | Болор шүр ХХК | JPY | 0.1 | 0.0 | 2.8 | 2.3 | 0.1 | 2.4 | |
| 7 | Эрд хул ХХК | MNT | 0.5 | 0.1 | 0.6 | 0.5 | 0.1 | 0.6 | |
| 8 | Сонгоулд ХХК | JPY | 0.0 | 0.1 | 2.4 | 17.4 | 2.2 | 19.6 | |
| 9 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | MNT | 1.2 | - | 1.2 | | | | |
| 10 | Инжир ХХК | USD | - | - | 0.3 | 4.3 | 2.1 | 6.3 | |
| 11 | Хамтын эх булаг ХХК | JPY | 0.0 | 0.0 | 0.8 | | | | Зээлийг хаасан |
| 12 | Ган хүдэр орд ХХК | JPY | - | - | 0.3 | - | 0.8 | 0.8 | |
| 13 | Монгема ХХК | JPY | 0.0 | 0.0 | 0.4 | 5.8 | 2.4 | 8.1 | |
| 14 | Хатант интернэшнл ХХК | MNT | 5.1 | 0.1 | 5.2 | 5.2 | 1.4 | 6.7 | |
| 15 | Пи си вай ХХК | MNT | 1.1 | 0.0 | 1.1 | 3.5 | 1.1 | 4.6 | |
| 16 | Пирамид-орд ХХК | MNT | - | - | 1.2 | 15.0 | 8.3 | 23.3 | |
| 17 | Мбү трейд ХХК | MNT | - | - | 0.7 | 7.1 | 5.1 | 12.2 | |
| 18 | Петролеум продакшн ХХК | MNT | 0.2 | 0.1 | 0.4 | 7.9 | 3.3 | 11.2 | |
| 19 | Мак цемент ХХК | USD | 0.1 | 0.0 | 174.7 | 18.9 | 8.2 | 27.1 | |
| | | MNT | 20.0 | 6.0 | 26.0 | | | | |
| | | | - | - | 200.7 | | | | |
| 20 | Кью эс си ХХК | USD | 0.1 | 0.0 | 172.5 | 145.9 | 46.7 | 192.6 | |
| 21 | Форс голд майнинг ХХК | MNT | 2.0 | 0.2 | 2.1 | | | | Зээлийг хаасан |
| 22 | Скайлэнд энержи ХХК | MNT | 0.3 | 0.0 | 0.3 | | | | Зээлийг хаасан |
| 23 | Нью хаппи ХХК | MNT | 1.5 | 0.1 | 1.6 | | | | Зээлийг хаасан |
| 24 | Монгол драй милк ХХК | USD | - | - | 4.9 | - | 8.2 | 8.2 | |
| 25 | Кредос ХХК | JPY | 0.1 | 0.0 | 2.8 | 2.3 | 3.3 | 5.6 | |
| 26 | Бэрэн групп ХХК | USD | 0.0 | 0.0 | 7.4 | 96.1 | 49.6 | 145.7 | |
| 27 | Монватт ХХК | EUR | 0.0 | 0.0 | 0.6 | | | | Зээлийг хаасан |
| 28 | Вояжер минерал ресурсес ХХК | JPY | 0.1 | - | 2.9 | | | | Зээлийг хаасан |
| | | Төгрөг | 431.9 | 137.8 | 569.8 | 593.8 | 325.7 | 919.4 | |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ЭРСДЭЛТЭЙ ЗЭЭЛҮҮД

| | | | 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн ... дугаар албан шаардлагын дүн | 2022 оны байдлаарх зээлийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | ЭГИЙН ГОЛЫН УСАН ЦАХИЛГААН СТАНЦ | USD | 28.0 | 43.8 |
| 2 | ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК | MNT | 170.6 | 152.4 |
| 3 | ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ | USD | 39.2 | 46.3 |
| | | | 237.8 | 242.5 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# АНХААРАЛ ТАВЬСАН БАЯРЛАЛАА

